



26

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
НАЛАЙХ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 57/Н

Налайх хот

М.Шинэбаярт буцалтгүй
тусламж олгох тухай

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12.2, компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.9 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орлогын нягтлан бодогч Мэндбаярын Шинэбаярын аав 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өвчний учир нас барсан тул эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн 3 360 000 /гурван сая гурван зуун жаран мянган/ төгрөгийг ажиллагсдын нийгмийн зардлаас гаргахыг Нийтлэг үйлчилгээний хэсгийн ахлагч, ахлах нягтлан бодогч /С. Амарбаясгалан/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.БАТСУУРЬ